

“АЛТАЙ ДАМНАСАН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ – ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” чуулга үүлзалт

“ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ МЭДЭЛЖИХ ҮЙЛ ЯВЦ БА МАНЛАЙЛАЛ” сэдэвт хэлэлцүүлэг

2023.06.13 10:00-11:15

Хүний эрхийг хангах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга  
Б.Болорсайхан

Ярианы сэдэв:

1. Хүний эрхийн хэм хэмжээ, жишигт харилцан адилгүй заасан ч жендэрийн эрх тэгш байдлыг хангах бол эдэлвэл зохих хүний эрх болно. Энэхүү эрхийг бодитой хангаснаар өнөөдөр манай улсад, мөн бүс нутагт, цаашилбал дэлхий дахинд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн зааг ялгаа, нийгмийн тэгш бүс байдал, охид, эмэгтэйчүүд, бэлгийн цөөнхийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг бууруулж эсвэл арилгаж чадна. Үүнтэй уялдан Тогтвортой хөгжлийн зорилго бүр цаанаа жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн зорилт, шалгуур, хэмжүүр, шалгуур үзүүлэлт агуулсан байдаг.
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх нь тогтвортой хөгжлийн салшгүй хэсэг билээ. Тэртээ 1986 онд хөгжлийн талаар улс орнууд санал нэгдэхдээ “хөгжих эрх нь эдэлвэл зохих эрх” хэмээн хүлээн зөвшөөрч, нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын хүрээнд оролцох, хувь нэмэр оруулах, үр шим хүртэх тасралтгүй үргэлжлэх үйл явц, үүгээрээ өөрийн бүх эрх, эрх чөлөөгөө эдэлнэ гэж үзсэн байдаг. Мөн 1987 онд тогтвортой хөгжлийг тодорхойлохдоо энгийнээр буулгавал “өнөөдөр амьдарч байгаа хүмүүс дараа үедээ гай болохгүй, нөөцийг ариг гамтай зарцуулан, дараа үедээ хадгалан дамжуулж өгөх” гэж тайлбарлаж болно. Аль нэг хүйс, нийгмийн бүлэг, эрх мэдлийн давуу этгээд байхаас үл шалтгаалан хүн бүр өсөж дэвжих, өөрийн амьдралаа бүтээж залах боломж бололцоо дүүрэн байх тухай ярьж байна. Манай Үндсэн хууль боловсруулагчид ч энэхүү үзэл баримтлалыг шингээж чадсан байдаг.
3. Бид ХХ зууны дунд хагасаас хойш улс орны хөгжлийн үйл явц хэрхэн өрнөж, олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүний эрхийн хэм хэмжээг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн, нийтлэг жишиг болгож, удалгүй хөгжилтэй салшгүй ойлголт болон тодорхойлж иржээ. Эдийн засгийн өсөлтөөр улсын хөгжлийг харахгүй, хүнийг нийгмийн цөмдөө байрлуулан, түүний эрх, эрх чөлөөг хэрхэн эдлүүлж байгаагаар улс орны хөгжлийг харж байна. Нэг үгээр хүн төрөлхтөн өөрийн алдаанаас сургамжлан улам ахиж дэвшиж байна. Бид ч урт хугацааны хөгжлийн стратегиа 2050 он хүртэлх байдлаар арав, арван жилээр үечлэн, өөрийн улсаа хөгжүүлэхээр хичээж байна.
4. Манай улсад “Хүний эрхийг дээдэлсэн нийгэм” хэмээх зорилтоор жендэрийн эрх тэгш байдлыг бүрэн хангасан, хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхүйц нийгэм ямар

байхыг тодорхойлсон юм. Бүх талын оролцоог хангасан зохистой тогтолцоотой байна гэдэг угтаа хүн бүрийн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хүний эрхийн түгээмэл соёл төлөвшинө гэсэн үг.

5. Дэлхий дахины дүр зураг харвал бидэнд хийх ажил их байгааг илэрхийлнэ.
6. Өнгөрсөн жилийн тоон мэдээнээс дэлхий дахинд, бүс нутагт нөхцөл байдал ямар байгааг харцгаая. Бүс бүсээрээ тогтвортой хөгжлийн зорилго хэрхэн биелж байгааг эндээс харна. Сааралтсан нь хангалттай өгөгдөл, тоо баримт байхгүй, улайсан, улбар өнгөтэй нь тухайн зорилгод хүрэхэд хол байгааг илтгэнэ. Манай улсын хувьд ч богино хугацаанд их зүйл хийх шаардлагатайг харж болно.
7. Эдийн засгийн өсөлтөөр улсын чансааг тогтоох бүс тухайн улсын хүн бүр хэрхэн хөгжиж байгаагаар хэмждэг. Мөн хүрээлэн буй орчноо одоо болон дараа үедээ доройтол, бохирдолгүй хадгалан үлдээх, амьдран байгаа нийгэмдээ хүн бүр адил тэгш эрх, боломж, бололцоотой байх, үүнд эдийн засаг дэмжлэг байдлаар хувь нэмэр оруулах, олон улс хамтдаа нэг нэгнээ түшин мөр зэрэгцэн урагшлах нь зүйтэй. Эмэгтэйчүүд эрх мэдэлжих нь тогтвортой хөгжилд оролцох, нийгмийн шударга ёс, хүрээлэн буй орчны тогтвортой байдал бүрдэх чухал тулгуур ажээ.